

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
2015 ОНЫ 1-3 ДУГААР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2015 оны 1-3 дугаар улиралд хэрэгжүүлсэн ажлыг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилан авч үзвэл:

Нэг. Хяналт шалгалтын ажлын чиглэлээр:

Баян-Өлгий, Ховд, Орхон, Архангай, Төв, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул аймгуудын архив, МУБИС, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Үндсэн хуулийн цэц, Шүүхийн ерөнхий зөвлөлийн архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд хяналт шалгалт явуулж, дүнг улсын байцаагчийн “Албан шаардлага”, “Дүгнэлт”, “Илтгэх хуудас”-аар гарган АЕГ-ын удирдлага болон холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын 25 жилийн ойг тохиолдуулан “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагчдын Анхдугаар зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, 25 жилийн үйл ажиллагааны ололт амжилт, хүрсэн үр дүн, тулгамдаж буй асуудал цаашдын зорилт, түүнийг шийдвэрлэх арга замуудын талаар хэлэлцүүлэв.

Зөвлөгөөний үеэр хэлэлцсэн асуудлууд, гарсан саналыг үндэслэн ХШҮДАХ-ээс “Улсын байцаагчдын анхдугаар зөвлөгөөний мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө” гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал: “Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах, эрхийг хүчингүй болгох тухай” Хууль зүйн сайдын 2014, 2015 оны тушаалаар томилогдсон бүх байцаагчдад шинэчилсэн үнэмлэхийг олголоо.

Төрийн архивын улсын байцаагч нарын 2015 оны хяналт шалгалтын ажлын хуваарь, төлөвлөгөөг хүлээн авч, хянан алдаа зөрчлийг арилгуулсны үндсэн дээр Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын Ерөнхий байцаагчаар батлуулж, төрийн архивуудад хүргүүлээ.

Төрийн архивуудаас 2014 онд хийсэн хяналт шалгалтын ажлын тайлан, мэдээ, ногдуулсан торгууль, шийтгэврийн талаарх статистик мэдээг хүлээн авч, нэгтгэн, хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж бичин улсын байцаагч нарт хүргүүлсэн.

Улсын байцаагч нараас захиргааны зөрчил илрүүлсэн шийдвэрт хяналт тавьж, торгууль, шийтгэврийн хуудасны зарцуулалтын тайланг гаргуулан хүлээн авч, нэгтгэсэн.

Төрийн ба төрийн бус 223 байгууллагын 765 нэр төрлийн хэвлэмэл хуудасны эх загварыг стандартын дагуу бэлтгэсэн байдалд хяналт тавьж, хэвлүүлэх зөвшөөрөл олгосон ба улсын төсөвт 30 орчим сая төгрөгийн орлого оруулж ажилласан байна.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын Ерөнхий байцаагч томилуулах тухай албан бичиг, Ерөнхий сайдын захирамжийн төсөл, танилцуулга боловсруулж ЗГХЭГ-т 02/322 тоот албан бичгээр хүргүүлсэн.

ХХЕГ, ГХЯ, ЦЕГ, Нийслэлийн ЗДТГ, ТЕГ-н улсын байцаагчийг томилуулан, Хууль зүйн сайдын “Улсын байцаагчийн эрх олгуулах, эрхийг хүчингүй болгох тухай” А/109 дүгээр тушаал гаргуулж, 1 ажилтанг улсын ахлах байцаагч, 2 ажилтныг улсын байцаагчаар тус тус томилуулж, 9 ажилтанд улсын байцаагчийн эрх олгуулж, 4 улсын байцаагчийн эрхийг цуцлуусан болно.

Хоёр. Улсын үзлэг явуулах ажлын хүрээнд:

“Улсын үзлэг явуулах тухай” Засгийн газрын 2015 оны 195 дугаар тогтоол, “Улсын үзлэг батлах явуулах төв комиссын бүрэлдэхүүн, удирдамжийг батлах тухай” Ерөнхий сайдын 124 дүгээр захирамжийг гаргуулав.

Энэхүү тогтоол, захирамжийг үндэслэн “Төв комиссын ажлын төлөвлөгөө”, “Улсын үзлэг явуулах хуваарь”, “Байгууллагын архивын ажлыг дүгнэх үзүүлэлт, аргачлал”, “Албан хэрэг хөтлөлтийн ажлыг дүгнэх үзүүлэлт, аргачлал”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдлыг дүгнэх үзүүлэлт, аргачлал”-ыг тус тус боловсруулан, Төв комиссын хурлаар батлуулж, Төв комиссын гишүүд болон үзлэгт хамрагдах яам, агентлаг, байгууллагуудад хүргүүлсэн ба АЕГ-ын цахим хуудсанд байршуулав.

Улсын үзлэг явуулах ажлын хэсгийгхнийг 2 удаа хуралдуулан, чиглэл, зөвлөмж өгөх, шаардлагатай ном гарын авлагаар хангах, нарийн бичгийн дарга нарыг томилох арга хэмжээг авсан ба улсын байцаагчийн дүгнэлт, албан шаардлага бичих загвар, үзлэгийн дүнгийн хуудасны нэгдсэн загвар гарган ажлын хэсгийнхэнд тарааж өглөө.

Төв комиссын хурлыг 2 удаа хуралдуулж, улсын үзлэгийн хуваарь, дүгнэх үзүүлэлт, аргачлал болон үзлэг зохион явуулахтай холбогдсон асуудлуудыг шийдвэрлүүлсэн. Одоогийн байдлаар тус хэлтсийн дарга, 3 улсын байцаагч, улсын үзлэгт хуваарийн дагуу оролцож нийт 21 аймаг, 30 сум, 31 байгууллагад улсын үзлэг хийн, дүгнэлтийг бичиж хүргүүлсэн байна.

Гурав. Хяналт, шинжилгээ-үнэлгээний ажлын хүрээнд:

“Төрийн архивуудын 2014 оны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ” хийж, Төрийн архивуудын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн дээр танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж бичин, төрийн архивуудад хүргүүлсэн.

АЕГ-ын 2014 оны үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, “Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам”-ын ҮТА-ын үйл ажиллагааны талаарх сар бүрийн статистик мэдээг нэгтгэн ХЗЯ-нд сар бүрийн 05-ны дотор 01-10 сарын мэдээг гаргаж хүргүүлсэн. Мөн Үндэсний төв архивын баримтыг цахимжуулах төлөвлөгөөт ажлын явцын үнэлгээ хийв.

АЕГ-ын 2014 оны үйл ажиллагаанд ХЗЯ-ны ХШҮДАГ-аас хийсэн хяналт шинжилгээний дүн, өгсөн зөвлөмж, албан даалгавар, Хөгжлийн санаачилга, бодлого судлалын төвөөс, АЕГ-аас үзүүлж буй төрийн үйлчилгээ ба хэрэглэгчийн сэтгэл ханамжийн байдалд хийсэн судалгааны тайлан, зөвлөмжийг үндэслэн “Хяналт, шинжилгээ-үнэлгээний үр дүн, гүйцэтгэлийг сайжруулах талаар АЕГ-аас 2015 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулж, батлуулан, зохион байгуулалтын нэгж, холбогдох удирдлагуудад тараан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

ХЗЯ-наас өгсөн “Хяналтын бүдүүвч”-ийн “Цахим засаг” Үндэсний хөтөлбөр, “Жендэрийн тэгш байдлыг хангах” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийсэн ажил, түүний хэрэгжилтийн явцын үнэлгээ хийж ХЗЯ-нд хүргүүлсэн.

АЕГ-ын Дэд даргын өгсөн үүргийн дагуу АЕГ болон бүтцийн нэгжүүдийн 1 дүгээр улирлын үйл ажиллагааны хэрэгжилтэнд явцын үнэлгээг хийж, дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулсан.

АЕГ-ын 2015 оны эхний 5 сарын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж, ХЗЯ-нд хүргүүлсэн.

АЕГ дээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн биелэлт гаргах, хяналт шинжилгээ хийх хуваарийг боловсруулан, батлуулж, ХЗЯ болон АЕГ, ҮТА-ын зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлэв.

Дөрөв. Дотоод аудитын ажлын хүрээнд:

Санхүүгийн үйл ажиллагааны аудитын чиглэлээр:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт Шилэн дансны цахим хуудас болон байгууллагын шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулсан,

байдалд АЕГ-ын 2015 оны 1 дүгээр улирлын байдлаар гаргаж Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.

АЕГ-ын Дэд даргын баталсан удирдамжийн дагуу АЕГ-ын 2015 оны 1, 2 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүнг Дотоод аудитын орон тооны бус зөвлөлийн болон Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан бөгөөд гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллаж байна.

Үйл ажиллагааны аудитын чиглэлээр:

АЕГ-ын Удирдлагын зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 5 дугаар хурлаас өгсөн үүрэг даалгаврын дагуу КГЗДАБА-т ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдалд дотоод аудит хийж, дүнг Дотоод аудитын орон тооны бус зөвлөлаар хэлэлцүүлэв.

Эрсдэлийн үнэлгээний чиглэлээр:

АЕГ-ын 2014 оны жилийн үйл ажиллагаа болон 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, тайланг ХЗЯ-нд хүргүүлсэн.

АЕГ-ын газар, хэлтсийн дарга нар төвүүдийн болон архиын эрхлэгч , төрийн захиргааны ажилтнуудад “Эрсдлийн менежментийн сургалт”-ыг зохион байгуулж ХЗЯ-ны ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Рэнцэнбямба, мэргэжилтэн Төмөр-Очир нараар хичээл заалгуулав.

Тендер сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт тавих зорилгоор АЕГ-ын 2015 оны А/15 дугаар тушаалаар байгуулагдсан “Үнэлгээний хороо”-ны бүрэлдэхүүнд оролцож тендер шалгаруулалтыг аргачлалын дагуу хийх саналыг оруулан, хүчингүй болгуулж, дахин тендер зарлууллаа

Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавих чиглэлээр:

Үндэсний аудитын газраас АЕГ-ын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, илэрсэн зөрчилүүдийг арилгах үүднээс өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Бусад чиглэлээр:

АЕГ-ын Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хуваарь боловсруулан, батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байгаа ба Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдох мэдээллийг цахим хуудсанд байршуулах хуваарь боловсруулж, батлуулж, хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан.

АЕГ-ын Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө (2015-2016 он), АЕГ-ын Дотоод аудитын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус боловсруулж, батлуулан ХЗЯ-нд хүргүүлсэн.

АЕГ-ын Дотоод аудитын 2014 онд хийсэн ажлын тайлан, Дотоод аудитын 2015 оны 1, 2 дугаар улирлын мэдээг гаргаж ХЗЯ-нд хүргүүлсэн.

ХЗЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас санаачлан хэрэгжүүлж буй “Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд дотоод аудит хийх, хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагуудын дотоод аудит хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах, туршлага солилцох хөтөлбөрт хамрагдсан.

Тав. Бусад ажлын хүрээнд:

Батлагдсан хуваарийн дагуу Сургалтын төвөөс зохион байгуулсан анхан шатны сургалтад **174** цаг, мэргэшүүлэх сургалтад **33** цаг, нийт **207** цагийн хичээл заасан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл, ЭМЯ, Төмөр зам, ЦЕГ-ын хүсэлтээр хэлтсийн ажилтнууд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 8 цагийн сургалт явуулсан.

“Төрийн архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт” гарын авлагыг эцэслэн боловсруулж, редакторлан, эх бэлтгэж, хугацаанд нь хэвлүүлэн, Улсын байцаагч нарын Анхдугаар зөвлөгөөнд оролцогчдод тараав.

Хууль зүйн яамнаас Стандартчилал хэмжил зүйн газрын төлөвлөгөөнд оруулах саналаа боловсруулж 03 дугаар сарын 09-ний өдрийн 01/205 тоот албан бичгээр хүргүүлсэн.

АЕГ-ын зохион байгуулалтын нэгжүүд газар, хэлтэс, архив, төвүүдээс архивын сан хөмрөгийн ашиглалтын судалгаа, лавлагаа мэдээллийн үйл ажиллагаа, хадгалагдаж буй баримтын хэмжээ, цомхотгосон орон тооны тухай судалгаа авч боловсруулан Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

ХЗЯ-аас ирсэн албан даалгаврууд нь Баримт бичгийн стандарт зөрчсөн талаар дүгнэлт гаргаж, зөрчлийг арилгуулахаар 2015 оны 06 дугаар сарын 16-ны 01/458 тоот албан бичгээр ХЗЯ-нд хүргүүлэв.